Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчин, хүний нөөцийн бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн,
Баяртогтох Дуламханд

2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангах | | | | | | | |
| 1 | Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, батлуулна. | Төлөвлөгөө, Засгийн газрын тогтоолын төсөл | Засгийн газрын 2020 оны 207, 2021 оны 18 дугаар тогтоол | Холбогдох тооцоо судалгаа хийж, аймаг, орон нутаг, нийслэлийн түвшинд бодлогын шийдэл хувилбар боловсруулан дунд хугацааны төлөвлөгөөний төсөл боловсруулна. | НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын техникийн дэмжлэгтэйгээр Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх бодлогын шийдэл боловсруулах зөвлөх үйлчилгээний хүрээнд нийслэлийн төрийн өмчийн сургуульд MNS 7005:2023 Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлагын гарааны үнэлгээг | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 50%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 50%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эхлүүлсэн. Орон нутгийн үнэлгээг 204 оны 9 дүгээр сард зохион байгуулна. Үнэлгээний дүнд үндэслэн төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж, ЗГ-ын хуралдаанд танилцуулна. 2023-2024 оны статистик мэдээгээр төрийн өмчийн 695 сургуулийн 246 нь сургуульд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байна. харин 649 сургууль нь хоолны газартай байгаа бөгөөд тэдгээрийн 28 хувь нь 2-4 хоолны газартай байна. хоолны газартай сургуулийн 323 нь MNS7005:2023 стандартын шаардлагыг хангасан байна. | | |
| 2 | Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээг хийж, нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна. | Хуулийн төсөл | Хуулийн үзэл баримтлалын төсөл | Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээг хийсэн байна. | Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн төслийн үзэл баримтлалд 1. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хүнсний хангамжийг төр, хувийн хэвшилтэй хамтран орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэгж байгуулах замаар тухайн орон нутгийн компани, нөхөрлөл, хоршоодын оролцоог хангаж, чанар аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хүртээмжтэй, тасралтгүй, тогтвортой үнээр ханган нийлүүлэлтийн нэгдсэн төвийг байгуулах; 2.Орон нутагт үйлдвэрлэдэг хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах зорилгоор орон нутгийн хөгжлийн сан, хоршоог хөгжүүлэх сангаас хөрөнгө зарцуулах эрхийг орон нутагт олгох; 3.Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд бүс, орон нутгийн онцлогтой уламжлалт хоол, ундааны хэрэглээ, түүний хангамж, үйлдвэрлэлийг дэмжсэн шийдвэрийг орон нутагт бие даан гарган хэрэгжүүлэх; 4.Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд олон талт санхүүжилтийн эх үүсвэр бүхий тогтолцоог төр, хувийн хэвшлийн хамтын зарчим | | байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүхий удирдлага, зохион байгуулалт, гүйцэтгэл хариуцсан бүтцийг бий болгох; 5. Сургуулийн нэг хүүхдэд ногдох хоолны зардлын бүрэн өртөгийг тооцон, төсөвт жил бүр тусгах; 6. Үдийн хоол хөтөлбөрийн үр дүн, хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжилтийн өөрчлөлтийг хэмжих, хянах тогтолцоог бий болгох зэргээр эрх зүйн зохицуулалтыг бүрэн хангах, эрх зүйн хэм хэмжээнүүдийн хоорондын зөрчил, давхардал, хийдлийг арилгах, бусад хууль тогтоомжтой уялдахад чиглэгдэх бөгөөд дор дурдсан харилцааг зохицуулахаар тусгасан. Хавсралт: 1 файл | | |
| 1.1. Сургуулийн өмнөх, ерөнхий болон тэгш хамран сургах боловсролын хөгжлийн чиглэлээр батлагдсан бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийн удирдлага, зохицуулалтыг хангах чиглэлээр дүрэм, журам, удирдамж, аргачлал, зөвлөмж боловсруулах, төслийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах | | | | | | | |
| 3 | Хүүхдийн хоолны зардлыг эцэг эх, асран хамгаалагчаас төвлөрүүлэх, зарцуулах аргачлалыг батлуулсан байна. | Сайдын тушаал | - | Аргачлалыг боловсруулж, батлуулсан байна. | Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс төвлөрүүлэх, зарцуулах аргачлалын төслийг Өвөрхангай, Дорнод, Говь-Алтай, Сүхбаатар, Увс аймгийн Боловсрол, | 1-р сар, 2-р сар | Өөрийн үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шинжлэх ухааны газар, зарим цэцэрлэгээс, нийслэлийн Сүхбаатар, Баянгол дүүргийн Боловсролын хэлтэс, зарим цэцэрлэгээс түүврийн аргаар санал авч, ирүүлсэн саналыг тусган сайжруулан 2024 оны 3-р сарын 22-нд хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт: БЕГ-ын Санхүү, төсвийн хэрэгжилт, зохицуулалтын газар, хоол үйлдвэрлэлийн хэлтэс, нийслэлийн төвийн 5 дүүргийн 10 цэцэрлэгийн эрхлэгч нийт 20 хүн заримт заалтыг хасах, найруулах санал хэлснийг аргачлалын төсөлд тусган 2024 оны 4 дүгээр сарын 11-нд ABLE системд байршуулан, холбогдох газар, хэлтсийн удирдлагад танилцуулж байна. Аргачлалын төслийг боловсруулахдаа байгууллагад нэмэлт данс нээхгүй, үндсэн дансанд хоолны зардлыг төвлөрүүлэх, өдрийн ирцийг боловсролын мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан | | төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүртгэх, мэдээлэх, тайлагнах, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон багш ирцийн бүртгэл мэдээллийг баталгаажуулах, санхүү хариуцсан албан тушаалтан эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон багшид тухай мэдээллийг нээлттэй өгч, цэцэрлэг болон хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт чирэгдэл, хүндрэл үүсгэхгүй байхаар бодолцон, 3 бүлэг, 18 заалттайгаар боловсруулсан. Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын даргад 4 дүгээр сарын 11-ны өдөр цахимаар танилцуулж байгаа, одоо болтол санал хэлэх, цааш явуулах талар чиглэл өгөөгүй байна.<br>Хавсралт: 1 файл | | |
| 4 | Үдийн хоолны өртөгт суурилсан санхүүжилтийн хувилбарыг боловсруулж, хэрэгжүүлнэ. | БШУ-ын сайдын тушаал, аргачлал | судалгааны тайлан | Өртөгт суурилсан санхүүжилтиийг хэрэгжүүлэх аргачлал, хяналт үнэлгээний төлөвлөгөөг | Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн суралцагчийн үдийн хоолны зардлыг өртөгт суурилсан байдлаар шийдвэрлэх боломжийн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | батлуулан төсөв санхүүжилтийг шийдвэрлэсэн байна. | судалгааг БСҮХ-тай хамтран Орхон аймагт зохион байгуулсан. Энэхүү судалгаанд Орхон аймгийн төрийн өмчийн 15 сургуулийн ус, цахилгааны 5 өдрийн хэрэглээ, тоног төхөөрөмж, засвар үйлчилгээнд сүүлийн 2 жилд зарцуулсан зардал, ажилчдын цалин хөлс, ариутгал халдваргүйтгэлийн зардлыг судлан үзэж, ҮДИЙН ХООЛНЫ ӨРТГИЙН 8 ХУВЬСАГЧИЙГ гаргасан. Үүнд: 1. Суурь хувьсах зардалд: а) гал тогооны ажилчдын үндсэн цалин, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл 46,5%, б) гал тогооны ажилтны нэмэгдэл, нэмэгдэл хөлс, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл 19,9%, 2. Бусад хувьсах зардалд: а) Гал тогооны ариутгал, үйлчилгээ, аюулгүй байдлын зардал зардал 2,9%, б) Ажилчдын сургалтын зардал 0,9%, в) Эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын | сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | үнэлгээ: 80%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үйлчилгээний зардал 0,5%, г) Ус, цахилгаан болон эрчим хүчний зардал 12,8%, д) Засварын зардал 3,2%, 3.Нөхөн хангалтын хувьсах зардал: а) Гал тогооны тоног төхөөрөмж, хэрэгслийн нөхөн хангалтын зардал14,6%, нийт 100% байна. Төрөөс хариуцах зардлын хувь хэмжээ 66,5%, үүсгэн байгуулагчийн хариуцах зардлын хувь 33,5% байна. Мөн хүүхдийн тооны итгэлцүүрийг 0,36-2,70 байхаар тооцон гаргасан. Энэхүү тооцоо судалгаанд үндэслэн үдийн хоолны зардлыг өртөгт суурилсан санхүүжилтэд шилжүүлэх талаарх Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулсан.<br>Хавсралт: 3 файл | | |
| 5 | "Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага" MNS 7005:2023 стандартын түвшинг | Стандартын шаардлага хангасан сургууль, цэцэрлэгийн эзлэх хувь | 2023 онд 60.8 хувь | Стандартыг хэрэгжүүлэх зөвлөмжийг боловсруулна. Стандартын үнэлгээ хийх удирдамж, үнэлгээний хуудсыг | Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх бодлогын шийдэл боловсруулах зөвлөх үйлчилгээний хүрээнд нийслэлийн төрийн өмчийн сургуульд | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 70%<br>Нэгжийн даргын үнэлгээ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тодорхойлох үнэлгээг зохион байгуулж, стандартын түвшинг дээшлүүлэх, зарим сургуулийн хоол үйлдвэрлэлийн газрыг нэгтгэн зохион байгуулах төлөвлөлт, үр ашгийг тооцон Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. | | | боловсруулан, хэрэгжүүлнэ. | MNS 7005:2023 Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлагын гарааны үнэлгээг эхлүүлсэн. Үнэлгээний урьдчилсан дүн 2024 оны 9 дүгээр сард гарна. Үнэлгээний хуудсыг Орхон аймагт 8 сургуульд урьдчилсан үнэлгээг хийж, туршсан. Мөн стандартын үнэлгээ хийх талаар аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газрын хоол хүнсний асуудал хариуцсан мэргэжилтэн нарт цахимаар мэдээлэл өгөх сургалт хийсэн.<br>Хавсралт: 3 файл | сар, 11-р сар, 12-р сар | төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |
| 6 | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургууль дотор шаардлага хангасан ундны цэвэр усаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ. | Ундны цэвэр усаар хангагдсан сургуулийн эзлэх хувь | 2023 онд 57.7 хувь | Нийт сургуулийн 70 хувийг шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангасан байна. | 2023-2024 оны статистик мэдээгээр нийт сургуулийн 72,9 % нь ус цэвэршүүлэгч төхөөрөмжөөр хангагдсан энэ нь ус цэвэршүүлэгч төхөөрөмжөөр хангадсан сургуулийн 72 хүүхдийн дунд нэг ус цэвэршүүлэгч төхөөрөмж ноогдож байна. Ерөнхий | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 0%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 30%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS 6782:2019-т 6.6.6-д зориулалтын ус цэвэршүүлэх төхөөрөмжийг 75 хүртлэх хүүхдийн дунд нэг байхаар тооцож давхар бүрт байршуулна гэсж заасан. БШУ-ы сайдын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн "Төлөвлөгөө баталж, эрх шилжүүлэх тухай" А/590 дүгээр тушаалаар Боловсрол, шинжлэх ухааны салбарн 2024 оны бараа худалдан авах төлөвлөгөөг баталсан. Уг төлөвлөгөөнд ерөнхий боловсролын сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжид 1,5 тэрбум төгрөг баталсан бөгөөд ус цэвэршүүлэгч тоног төхөөрөмжийг тусгайлан заагаагүй. Мөн 2024 оны гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах тендерийн техникийн тодорхойлолтод ус цэвэршүүлэгч төхөөрөмж багтаагүй байна. НҮБ-ын Хүүхдийн сангийн уур амьсгалын өөрчлөл, ус ариун цэврийн хөтөлбөрт хүсэлт тавьсан хэдий ч | | байдал: 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | одоогоор уулзалт зохион багйуулагдаагүй байна. | | |
| 7 | Боловсролын сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэлийн хүний нөөцийн норматив, ажил мэргэжлийн стандартыг боловсруулж батлуулна. | Хүний нөөцийн нормативын тушаалын төсөл, ажил мэргэжлийн стандарт | Ажил мэргэжлийн стандартын төсөл | Боловсролын сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэлийн хүний нөөцийн норматив, ажил мэргэжлийн стандартыг боловсруулж батлуулсан байна. | Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын "Орон тооны хязгаарын жишиг норматив батлах туахй" 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/85/34 дугаар хамтарсан тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилтны орон тооны хязгаарыг жишиг нормативыг баталсан. Үүнд: 3-4 бүтэглтэй цэцэрлэгт 1 тогооч, 3-11 хүртэл бүтэгтэй цэцэрлэгт 1 гал тогооны туслах ажилтан, 5-17 ба түүнээс дээш бүлэгтэй цэцэрлэгт 2 тогооч, 12-17 ба түүнээс дээш бүлэгтэй цэцэрлэгт 2-3 гал тогооны туслах ажилтан ажиллахаар баталсан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, ажилтны орон тооны жишиг хязгаарыг Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлахаар | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар | Өөрийн үнэлгээ: 70%<br><br>Нэгжийн даргын үнэлгээ: 70%<br><br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тогтсон. Энэхүү нормативд 101-с дээш хүүхэдтэй сургууль бүрд 1 хоолзүйч, 100 хүртэлх болон 101-300 хүртэлх хүүхэдтэй сургуульд 1 тогооч, 301-дээш 2-6 хүртэлх тогооч, 1-3 хүртэлх гал тогооны туслах ажиллахаар тооцон санал хүргүүлсэн. 2 яамны ярилцан тохирсон хувилбарт 301-дээш хүүхэд сургууль бүрд 1 хоолзүйч, 300 хүртэл суралцагчтай бага сургуульд 1 тогооч, 301-1200 суралцагчтай бага сургуульд 2 хүртэл тогооч, 1201-ээс дээш суралцагчтай бага сургуульд 500 хүүхэд тутамд 1 тогоочийг хувьсах зардлаар тооцож олгосон төсөвт багтаан ажиллуулахаар тогтсон байна.<br>Хавсралт: 2 файл | | |
| 8 | Хоол үйлдвэрлэлийн ажилчдын ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр Бүсийн сургагч багшийг бэлтгэнэ. | Бэлтгэгдсэн сургагч багшийн тоо | - | Сургагч багшийг бэлтгэсэн байна. | Койка олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх төслийн | 4-р сар, 5-р сар, 6-р сар | Өөрийн үнэлгээ: 0%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 30%<br>Нэгжийн даргын үнэлгээ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүрээнд “Хүүхдийн хоол үйлдвэрлэл, шим тэжээлийн сургалт, арга зүйн үндэсний төв”-ийг Монгол Улсын Шинжлэх ухаан технологийн их сургуулийг түшиглэн байгуулна. энэхүү төюийн үйл ажиллагаа 2024 оны 9 дүгээр сарын 1-ны өдөр нэхээр төлөвлөн ажиллаж байна. Энэхүү төвөөр дамжуулан танхим болон цахимаар сургагч багшийг бэлтгэнэ. | | төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |
| 3.1. Сургуулийн өмнөх, ерөнхий болон тэгш хамран сургах боловсролын хөгжлийн чиглэлээр батлагдсан бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийн удирдлага, зохицуулалтыг хангах чиглэлээр дүрэм, журам, удирдамж, аргачлал, зөвлөмж боловсруулах, төслийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах | | | | | | | |
| 9 | Боловсролын сургалтын байгууллагад хамрагдаж буй хоол тэжээлийн тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн хооллолтын байдлыг үнэлэх арга зүйн удирдамжийн төсөл боловсруулах | Удирдамжийн төсөл | - | Холбогдох судалгаа, мэдээлэл цуглуулж, сан бүрдүүлнэ | БШУ-ы сайдын 2024 оны "Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, зардал батлах тухай" А/21 дүгээр тушаалаар Хоол тэжээлийн тусгай хэрэгцээтэй суралцагчдын хооллолтын байдлыг үнэлэх аргачлал, хоол зүйч, тогооч нарт зориулсан сургалтын гарын авлага боловсруулах, сургалтыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг БСҮХ, ШУТИС, АШУИС, ЯХИС, ерөнхий | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсролын 63,29,25 дугаар сургууль, 10 дугаар цэцэрлэгийн төлөөлөл бүхий 14 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ажлын хэсгийн судлаачдын баг тусгай 6 сургуулиас холбогдох мэдээллийг нарийвчлан авч, түүнд үндэслэн гарын авлагын бүтэц, хамрах хүрээ, үнэлгээний арга зүйг боловсруулахаар тогтож, эхний мэдээллийг цуглуулсан. Тусгай хэрэгцээт хүүхдийн бие махбодын онцлог, ялгаатай хэрэгцээнээс хамаарч хоол тэжээлээр авах илчлэг шимт бодис болон хоолны бүтэц, найрлагын талаар олон улсын туршлагыг судлах сургалтыг Япон Улсад 2024 оны 04 дүгээр сарын 14-21-ний өдрүүдэд зохион байгуулж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс 5 төлөөлөл хамрагдсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Менежментийн баг, хоолзүйн баг, хэл, хөдөлгөөн засал-эмчилгээний баг гэсэн үндсэн 3 багт хуваан, гарын авлагыг 4 бүтэцтэй | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байхаар тооцон ажиллаж байна.<br>Хавсралт: 4 файл | | |
| 3.2. Төрийн албан хаагчийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлж, хамтран ажиллах | | | | | | | |
| 10 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | Албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн тайлан | - | Албан бичиг, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн, хариу өгсөн байна. | тайлант хугацаанд 27 албан бичиг ирснээс хариутай 19 албан бичиг, 1 өргөдөл ирснийг хугацаанд шийдвэрлэсэн. Мөн тайлант хугацаанд 50 албан бичиг боловсруулж хүргүүлснийг 31 албан бичгийг бусад байгууллагад боловсруулсан хүргүүлсэн байна. Гол утга нь: хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр батлагдсан тушаал, шийдвэр, дүрэм, журмыг баталгаажуулах, батлагдсан барим бичгийн хэрэгжилтийг хангах, холбогдох судалгаа, мэдээлэл тооцоолол ирүүлэх зэрэг байна. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 11 | Төрийн болон Төрийн бус байгууллага, иргэдтэй эрхэлсэн ажлын чиглэлээр хамтран ажиллаж, зөвлөгөө, мэдээлэл өгнө. | Хамтын ажиллагааны тайлан, мэдээлэл | - | Шаардлагатай хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ, тайлан мэдээллийг цаг хугацаанд нь | НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын техникийн дэмжлэгтэйгээр Монголын логистикийн холбооны гүйцэтгэсэн "Ерөнхий боловсролын | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | боловсруулж, хэрэгжүүлсэн байна | сургуулийн үдийн хоол хөтөлбөрийн хүнсний хангамжийн оновчтой шийдэл, төлөвлөлт боловсруулах, политехник коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн чадавхыг бэхжүүлэх замаар сургалтын байгууллагад хагас боловсруулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх судалгаа"-ны тайланг 2024 оны 1-р улиралд цаасаар хүлээн авсан. Судалгаагаар ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол, хөтөлбөрийн хүнсний хангамжийн оновчтой хувилбар боловсруулах, үүнд логистикийн сүлжээ, сум, аймаг, нийслэлийн хүнсний хангамжийн схем, төр, хувийн хэвшлийн хамтарсан түншлэлээр хүнсний хангамжийг шийдвэрлэх хувилбар боловсруулан тайланг хүлээлгэн өгсөн. Судалгааны багийг ажиллах хугацаанд шаардлагатай мэдээ, мэдээллийг өгч, зөвлөн туслаж ажилласан.<br>Хавсралт: 1 файл | сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, ажлын чиг үүрэгтэй холбоотой ном, гарын авлагыг судална. | Эрхэлсэн ажлын чиг үүрэгт хамаарах шинээр батлагдсан хууль тогтоомжийг судлах, мэдээлэлийн сан бүрдүүлнэ. | 9 хууль, ЗГ-ын 6 тогтоол, 5 стандарт, 5 журам, 2 жагсаалт, 2 норматив. | Судалсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр (тоогоор) | Боловсролын багц, хууль, ЕБСХХҮ-ний тухай хууль, Хоол хүнсний чиглэлийн хууль, тогоомж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон түүнийг дагалдах дүрэм журмыг судлан, Мөн яамны мэдээллийн цагт тогтмол сууж байна. Түүнчлэн төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй 7:4:10 сургалтад цахим сургалтад хамрагдсан. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% |
| 2 | Байгууллага болон мэргэжлийн байгууллагаас зохион байгуулах сургалт, | Байгууллага, мэргэжлийн байгууллагаас зохион байгуулах дунд, богино | - | Байгууллага, мэргэжлийн байгууллагаас зохион байгуулах дунд, богино | ТЗУГ-аас зохион байгуулсан мэдээллий цагт тогтмол хамрагдсан. ТАЗ-өөс зохион байгуулсан 7:4:10 "Монгол | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийн цагт бүрэн хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлнэ. | хугацааны сургалтад танхимаар болон цахимаар хамрагдана. | | хугацааны сургалтад танхимаар болон цахимаар хамрагдана. | төрийн зүтгэлтний хэв шинж (XX зууны эхэн хагас), Төрийн жинхэнэ албан хаагчийг томилох үйл ажиллагаанд тавих хяналт сургалтад хамрагдсан. Мөн Койка ОУБ-тай хамран хэрэгжүүлж буй "Монгол улсын ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг сайжруулах, ячадавхыг бэхжүүлэх" төслийн хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан танхимыг 7 өдрийн сургалтад бүрэн хамрагдаж, амжилттай дүүргэсэн. | сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | үнэлгээ: 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчин, хүний нөөцийн бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн,
Баяртогтох Дуламханд /................................................./ Огноо: ........................